



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/22

Чингис хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах, ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авах зарим арга хэмжээний тухай” А/570 дугаар захирамжийн 1 дэх заалтыг зөрчиж согтууруулах ундаа худалдсан Баянмөнх сумын “Энхмагнай” ХХК-ний хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010091